

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө

Эрүүл мэндийн яам

2023 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны			
1	1.1. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;	-Баримтжуулсан байх -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) - Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.	Авлигыг мэдээлэх утас 110, Авлигын эсрэг нэгдье, Үгүй гэж хэлээд өөрчилье аяны нийт 13 шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас зэргийг Эрүүл мэндийн яам болон харьяа 20 эрүүл мэндийн байгууллага өөрсдийн албан ёсны цахим хуудас болон фэйсбүүк хуудас мөн Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудын нийт 22 лед дэлгэц, 90 самбараар дамжуулан нийтэд түгээсэн байна. Тухайлбал "Үгүй гэж хэлээд өөрчилье" шторкыг Эрүүл мэндийн яамны фэйсбүүк хуудсаар дамжуулан нийтэд хүргэсэн хандалтын тоо-8700, Улсын гуравдугаар төв эмнэлгийн фэйсбүүк хуудсаар дамжуулан нийтэд хүргэсэн хандалтын тоо-13200, Улсын хоёрдугаар төв эмнэлгээс олон нийтэд хүргэсэн хандалтын тоо-100,955. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн фэйсбүүк хуудсаар дамжуулан нийтэд хүргэсэн хандалтын тоо-1652 байна. Хавсралт нийт : 24 Файл : 5 Зураг : 19

2	1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	1. 12 дугаар сарын 09-ны өдөр Олон улсын авлигын эсрэг өдөр... Энэ өдрийг тохиолдуулан нийт эрүүл мэндийн салбарыг төлөөлөн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс нээлтийн арга хэмжээг Эрүүл мэндийн яам, Авлигатай тэмцэх газар, тус төвийн ёс зүйн салбар хороо хамтран нийт эмч, сувилагч, эмнэлгийн ажилчдад зохион байгууллаа. Энэ өдөрлөгийн хүрээнд МУ-ын хэмжээнд “Авлигын эсрэг нэгдье. Үгүй гэж хэлээд өөрчилье” уриан доор ЭХЭМҮТ-ийн нийт тасаг нэгжүүд нь “Хүнд сурталгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх”, “Баярлалаа гэдэг үг бидэнд хангалттай” гэсэн уриатайгаар 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл бүх тасаг нэгжүүд үйлчлүүлэгч рүү чиглэсэн арга хэмжээ зохион байгуулахаар нэгдлээ. https://www.facebook.com/iaacmn/videos/669674192010088/ https://www.facebook.co Мөн дараах эрүүл мэндийн байгууллагууд Олон улсын авлигын эсрэг өдрийг тохиолдуулан арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1. ЭНЭҮТ-II 2. УНТЭ 3. УХТЭ-
3	1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; - Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулж, жилд 2 удаа мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Мөн Эрүүл мэндийн яам албан хаагч нартаа зориулан мэдээллийн буланг ажиллуулж байна. Хавсралт : 16 зураг

4	<p>1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.</p>	<p>1. 2023 оныг "Бидэнд таны баярлалаа гэдэг үг л хангалттай" уриан дор Эрүүл мэндийн яам, ЭНЭҮТ-II, УХТЭ манлайлан 3 төрлийн шторкийг цуврал байдлаар бэлдэж өөрийн болон Авлигатай тэмцэх газрын албан ёсны пэйж хуудсаар дамжуулан түгээсэн. Мөн "Бидэнд таны баярлалаа гэдэг үг л хангалттай" зурагт хуудсыг бэлтгэсэн.</p> <p>ЭМЯ- https://fb.watch/nqdmgS6GR9/?mibextid=RUbZ1f ЭНЭҮТ-II- https://www.facebook.com/100095647687579/videos/729056228694696 УХТЭ- https://www.facebook.com/share/v/ZMkUo7wbDPWoY2tx/?mibextid=KsPBc6</p> <p>2. "Авлигын эсрэг нэгдье. Үгүй гэж хэлээд өөрчилье" уриан дор Эрүүл мэндийн яам, харьяа эрүүл мэндийн нийт 12 байгууллага нэгдэж буйгаа илэрхийлсэн ведио бүтээж, нийтэд түгээн ажилласан. Нэгдсэн байгууллагуудын хийсэн ведионы холбоос: ЭМЯ- https://www.facebook.com/share/v/woFcmc3jBzcrLLbo/?mibextid=KsPBc6 УГТЭ -https://fb.watch/oNccZw06NT/</p>
2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах			

5	2.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Тайлант хугацаанд тус яамнаас салбарын хэмжээнд 8 удаа сургалт зохион байгуулсан.Үүнд: -Авлига ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нийт 599 эрүүл мэндийн ажилтан, 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр 498 эрүүл мэндийн ажилтанд нийт 2 удаа цахим сургалтыг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан. Төрийн албанд анх удаа томилогдсон 1 албан хаагч АТГ-аас зохион байгуулсан сургалтад 2023 оны 11 дүгээр сард хамрагдсан.2023 оноос эхлэн зөвхөн Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнаар хязгаарлахгүйгээр нийт эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч нарт чиглэсэн сургалтыг ЭБАТ-ууд өөрсдөө зохион байгуулдаг болохыг зорьж байна. Энэ ажлын хүрээнд тус яамнаас Авлигатай тэмцэх газарт хүсэлт гаргасны дагуу 2023 оны 06 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Эрүүл мэндийн салбарын 10 эрх бүхий албан тушаалтан (эбат) Авлигын эсрэг сургалт сурталчилгааг зохион байгуулах сургагч багшийн сургалтад анх удаа хамрагдаж, амжилттай төгсөж, гэрчилгээ авсан. Сургагч багш нар дараах сургалтыг зохион байгуулсан. Үүнд:
---	---	---	--

6	<p>2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.</p>	<p>-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтнүүд болон шинжээч нарт 2023.11.21-ний өдөр Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн асуудал болон Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн чиглэлээр шинэчлэгдсэн эрх зүйн баримт бичгийг танилцуулах сургалтыг танхим, цахим хосолсон байдлаар зохион байгуулсан. -Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын 2023.11.13-ны өдрийн А/383-р тушаалаар батлуулсан. Тусгай зөвшөөрөл шинээр бүрдүүлэх сунгалттай холбоотой мэдээллийг шинэчлэн ЭМЯ-ны цахим хуудсанд байршууллаа. https://moh.gov.mn/p/140 -“Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, шинжээчийн ажиллах журам батлах тухай” журмыг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын 2023.11.20-ны өдрийн А/402-р тушаалаар батлуулсан. Тушаалыг ЭМЯ-ны цахим хуудсанд байршуулсан. -Тусгай зөвшөөрлийн комиссын хурлыг</p>
<p>3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох</p>			

7	<p>3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;</p>	<p>-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; - Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамнаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай нийт 329 гэрээ (Хөлсөөр ажиллах, Ажил гүйцэтгэх) байгуулсан байна. 2022 оноос эхлэн талууд гэрээ байгуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үндэслэн байгуулахаар гэрээний төслийг өөрчилж, мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>Хавсралт : 1 зураг</p>
---	---	--	---

8	3.2. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.	Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналт хэрэгжүүлэх журмыг хэрэгжүүлэх талаар 2023 оны 10 дугаар сард АТГ-аас ЭБАТ-д сургалт хийсний дагуу Эрүүл мэндийн яамнаас харьяа эрүүл мэндийн байгууллагуудад олон нийтийн хяналт хэрэгжүүлэх тухай чиглэл хүргүүлсэн. Үүний дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс олон нийтийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, "Түншлэлийг дэмжих төв" ТББ-ыг сонгон шалгаруулж, хүний нөөцийн хөгжлийн байдалдаа дүн шинжилгээ хийлгэж, тайланг эцэслэн гаргаад байна. Тайлангаар ирүүлсэн зөвлөмжийг 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Дэлгэрэнгүй тайланг хавсаргав. УНТЭ-ээс 2023.11.17-ны өдөр сонгон шалгаруулалт зарласан боловч материал ирээгүй. Иймд дахин 2023.11.30-нд сонгон шалгаруулалтыг зарлаад байна. ЭХЭМҮТ-өөс 2023.10.03-ны өдөр олон нийтийн хяналт хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан боловч мөн материал ирээгүй байна.
4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах			

9	<p>4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/</p>	<p>-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх ;</p>	<p>Төрийн үйлчилгээг шуурхай, хялбар, шат дамжлагыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. -2022 оны 01 сараас эхлэн Эрүүл мэндийн байгууллагын Магадлан итгэмжлэлийн цахим системийг хөгжүүлэн, хэрэглээнд нэвтрүүлж ажиллаж тус системээр эрүүл мэндийн байгууллагууд баримт бичиг бүрдүүлэх, ажлын албанд ирүүлэхдээ биечлэн олон дахин ирэх шаардлагагүй болсон. Энэ цахим системээр материалыг буцаах, засварлах баримт бичгийг хугацаа алдахгүй тухай бүр нь харж, засварлах боломжтойгоос гадна магадлан итгэмжлэлд хамрагдахаар гаргасан хүсэлтийн явц, төлөвтэй тухай бүр танилцах шийдвэрлэлтийн явцыг шууд харах боломжтой. 2023 оны жилийн эцсийн байдлаар 978 эрүүл мэндийн байгууллагыг цахим системд бүртгэсэн. ЭМС-ын 2019 оны А/566 дугаар тушаалын нэг, хоёрдугаар хавсралтын хүрээнд тохиолдол, эрсдэлийг бүртгэх мэдээний нэгдсэн өгөгдлийн санг бий болгох зорилготой программыг нэвтрүүлэн ажиллаж байна. •Программ нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо- 540 •Программд ажиллаж байгаа</p>
---	--	---	---

10	4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; - Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	ЭМЯ-наас “Эмчээ сонсьё” хэлэлцүүлгийг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр, олон улсын сувилагчийн өдрийг угтан “Сувилагчаа сонсьё” уулзалт хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 8-ны өдөр тус тус зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн, УИХ-ын гишүүн Б.Бейсен, Эрүүл мэндийн сайдын зөвлөх Ц.Эрдэмбилэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Оюунчимэг, Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дуу хоолой төрийн бус байгууллагын дарга Б.Содномпил, холбооны төлөөлөл, хөдөө орон нутаг болон нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарыг төлөөлөл болох 100 гаруй оролцогчид оролцсон. Эрүүл мэндийн салбарт иргэдээс ирүүлж байгаа өргөдөл гомдлын дийлэнх нь иргэдэд үзүүлж байгаа мэргэжлийн тусламж, үйлчилгээ гэхээсээ илүүтэй эрүүл мэндийн ажилтны харилцаа хандлага, байгууллагын үйлчилгээний соёлтой холбогдон гарч байна. Тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй, зохион байгуулалт, үйлчилгээний соёл хангалтгүй, эмч, эмнэлгийн
11	4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	-Бодитой үр дүнг тооцсон байх; - Тайланд нотломжийг хавсаргасан байх	Эрүүл мэндийн яам Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдээс Эрүүл мэндийн байгууллагуудын авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг нэгдсэн байдлаар боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудас болон 13.13.mn-ээр судалгааг авч байна. Судалгааны үр дүнг 2024 оны 01 дүгээр сард нэгтгэн, сайжруулах асуудлыг тодорхойлж, 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. Хавсралт : 4 файл
5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх			

12	5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; - Арга хэмжээнд удирдлагын - Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран боловсруулж, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр батлуулж, батлагдсан төлөвлөгөөг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 2/878 тоот албан бичгээр хүргүүлсэн. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, 2022 оны жилийн эцсийн тайлангийн үнэлгээ болон ЭБАТ-ын үйл ажиллагааг Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудын Эрх бүхий албан тушаалтнууд нийт албан хаагч нарт 1,2 дугаар улиралд багтаан танилцуулсан бөгөөд Хөгжил дэвшилд 110 мэдээллийн самбарт Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг байршуулж албан хаагчдаас гадна үйлчлүүлж буй иргэдийг тус төлөвлөгөөтэй танилцах боломжоор хангасан. Мөн Эрүүл мэндийн салбарын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс зөвхөн яамны төлөвлөгөөг салган тусад нь батлуулж, нийт газар хэлтсийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээн авсан. 2023 оны жилийн эцсийн тайланг Авлигатай
----	---	--	--

13	5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	Тайлант онд Авлигатай тэмцэх газраас нийт 3 зөвлөмж ирүүлсэн. Үүнд: 1. Авлигатай тэмцэх газраас 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 03/11425 дугаар албан бичгээр Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн нэгжүүдэд ажиллаж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар нийт 10 зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу холбогдох албан тушаалтнууд ажиллаж, 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 2/3981 дугаар албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг хүргүүлсэн. АТГ-аас зөвлөмжийн биелэлтийн талаар тус яамны холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж, зөвлөмжийн биелэлтийг сайжруулах чиглэл аван ажиллаж байна. (Зөвлөмжийн биелэлтийн тайланг хавсаргав.) 2.. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн 8 гишүүн 2023 оны 09 дүгээр сарын сарын 22-ны өдөр тус яаманд ажиллаж, Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллгааны ил тод байдал, Эрүүл мэндийг дэмжих сан, түүний хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл, Гадаад эмчилгээний эрх зүйн зохицуулалт, холбогдох мэдээлэл, Салбарын
----	--	---	--

14	5.3. Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; - khutulbur.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх, - Тайлагнасан байх.	Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх 7 ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Мөн Эрүүл мэндийн яамны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хариуцсан газар хэлтсийг үүрэгжүүлсэн. Мөн Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл тус яаманд 2023.09.22-ны өдөр тус яамны удирдлагуудтай уулзаж, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, эрүүл мэндийг дэмжих сан, гадаад эмчилгээ, санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны ил тод байдалтай тус тус танилцсан. АТГ-ОНЗ-өөс дээрх уулзалтын дагуу ирүүлсэн зөвлөмжийг хариуцсан газар, хэлтэст хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт : 3 файл
----	--	---	--

15	<p>5.1. Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;</p>	<p>Тайланд нотломжийг хавсаргасан байх.</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран боловсруулж, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр батлуулж, батлагдсан төлөвлөгөөг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 2/878 тоот албан бичгээр хүргүүлсэн. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, 2022 оны жилийн эцсийн тайлангийн үнэлгээ болон ЭБАТ-ын үйл ажиллагааг Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудын Эрх бүхий албан тушаалтнууд нийт албан хаагч нарт 1,2 дугаар улиралд багтаан танилцуулсан бөгөөд Хөгжил дэвшилд 110 мэдээллийн самбарт Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг байршуулж албан хаагчдаас гадна үйлчлүүлж буй иргэдийг тус төлөвлөгөөтэй танилцах боломжоор хангасан. Мөн Эрүүл мэндийн салбарын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс зөвхөн яамны төлөвлөгөөг салган тусад нь батлуулж, нийт газар хэлтсийн дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээн авсан. 2023 оны жилийн эцсийн тайланг Авлигатай</p>
----	--	---	---

16	<p>5.2. Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;</p>	<p>Тайлант онд Авлигатай тэмцэх газраас нийт 3 зөвлөмж ирүүлсэн. Үүнд:</p> <p>1. Авлигатай тэмцэх газраас 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 03/11425 дугаар албан бичгээр Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн нэгжүүдэд ажиллаж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар нийт 10 зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу холбогдох албан тушаалтнууд ажиллаж, 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 2/3981 дугаар албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг хүргүүлсэн. АТГ-аас зөвлөмжийн биелэлтийн талаар тус яамны холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж, зөвлөмжийн биелэлтийг сайжруулах чиглэл аван ажиллаж байна. (Зөвлөмжийн биелэлтийн тайланг хавсаргав.)</p> <p>2.. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн 8 гишүүн 2023 оны 09 дүгээр сарын сарын 22-ны өдөр тус яаманд ажиллаж, Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллгааны ил тод байдал, Эрүүл мэндийг дэмжих сан, түүний хөрөнгийн зарцуулалтын мэдээлэл, Гадаад эмчилгээний эрх зүйн зохицуулалт, холбогдох мэдээлэл, Салбарын</p>
----	---	---

17	<p>5.3.1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн болон тусгай эмнэлгүүдийн дотоод зохион байгуулалт, байршлыг иргэдэд ойлгомжтой тэмдэгжүүлэх, эмнэлгүүдийн хүлээн авах, яаралтай тусламж үзүүлэх хэсгийг иргэн үйлчилгээ авахад чирэгдэлгүй болгох зорилготой аяныг улсын хэмжээнд зохион байгуулах;</p>	<p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын гадна, дотно орчин, хаягжилт, үйлчлүүлэгчийг дэмжих нэгж, ажиллах албан хаагчдад тавигдах шаардлага, харилцаа хандлагын зарчмыг тусгасан “Эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 үндэсний стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн С/31 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангахад чиглэсэн дэмжлэгт үйл ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>Эрүүл мэндийн сайд /ЭМС/-ын 2023 оны “Стандартын хэрэгжилтийг хангах тухай” А/274 дүгээр тушаалаар энэхүү стандартыг эрүүл мэндийн ажилтнуудад танилцуулах, сурталчлахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосон бөгөөд сургагч багш бэлтгэх 2 удаагийн сургалтад нийт 90 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулан зохион байгуулсан.</p> <p>ЭМЯ-ны харъяа эмнэлгүүдийн “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын хэрэгжилтэд 2023 оны 12 дугаар сард тус яамны Салбарын хяналтын газраас хяналт, шалгалт</p>
----	---	---

18	5.3.2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн үйлчилгээний удирдамж /заавар/ баталж, хэрэгжүүлэх;	<p>“ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА MNS 7014:2023” СТАНДАРТ</p> <p>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын гадна, дотно орчин, хаягжилт, үйлчлүүлэгчийг дэмжих нэгж, ажиллах албан хаагчдад тавигдах шаардлага, харилцаа хандлагын зарчмыг тусгасан “Эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 үндэсний стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн С/31 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг хангахад чиглэсэн дэмжлэгт үйл ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>Эрүүл мэндийн сайд /ЭМС/-ын 2023 оны “Стандартын хэрэгжилтийг хангах тухай” А/274 дүгээр тушаалаар энэхүү стандартыг эрүүл мэндийн ажилтнуудад танилцуулах, сурталчлахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосон бөгөөд сургагч багш бэлтгэх 2 удаагийн сургалтад нийт 90 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулан зохион байгууллаа. Дараах линкээр стандарттай танилцана уу.</p>
----	---	---

19	5.3.3. Эмнэлгийн байгууллагуудын авто зогсоолын талаарх судалгаа гаргаж, хууль, журамд нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.9 дэх хэсэгт “Үйлчлүүлэгчийн автомашины зогсоол ашиглалтын төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд авахгүй” байхаар журамласан. Гэвч энэхүү журам хэрэгжихгүй байгаа талаар үйлчлүүлэгчдээс санал, гомдол Авлигатай тэмцэх газарт удаа дараа ирсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн яам, Авлигатай тэмцэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн замын хөгжлийн газрын төлөөлөл нарын хамтарсан уулзалтыг 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Авлигатай тэмцэх газарт зохион байгуулсан. Уг уулзалтаар төрийн өмчит нэгдсэн, мэргэшлийн эмнэлгүүдийн гаднах авто зогсоолын төлбөртэй үйлчилгээ эрхлэхтэй холбоотой асуудал болон “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам”-ын холбогдох зохицуулалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар харилцан санал солилцсон. Энэ ажлын хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудын автомашины зогсоолын ашиглалтыг сайжруулах зорилгоор “Мэдээлэл ирүүлэх тухай”</p>
20	5.3.4. Эмнэлгүүдийн төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, тарифын судалгаа хийх, хуульд нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулах;	<p>Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлж буй төлбөртэй тусламж , үйлчилгээтэй холбоотой дүрэм, журам, тарифыг судлан үзэж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа хийж нийт 18 Эрүүл мэндийн байгууллагын захирлын баталсан дүрэм журмыг хүчингүй болгосон. Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.</p> <p>Хавсралт : 1 файл</p>

21	5.3.5. АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пейж хуудсыг эмнэлгийн мэргэжилтнүүдээр дагуулах ажлыг зохион байгуулах;	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хамтран ажиллах тухай албан бичгийн дагуу АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пейж хуудсыг идэвхтэй дагах тухай дотоод меморандумыг Газар, хэлтэст хүргүүлж, яамны дотоод сүлжээнд байршуулсан. Мөн харьяа агентлаг, эрүүл мэндийн байгууллагад тус хуудсуудыг дагаж, хамтран ажиллах тухай 2/1356 тоот албан бичгийг 2022 оны 3 дугаар 28-ны өдөр хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус албан бичгийн дагуу эрүүл мэндийн яамны харьяа 24 байгууллага цахим хуудаастаа Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа гэсэн цэсийг нэмж, мэдээллээр баяжуулан ажиллаж байна. Мөн АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пейж хуудсыг дагах тухай мэдээллийг Эрүүл мэндийн байгууллага бүр дотоод сүлжээндээ байршуулан, сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хүрээ амаржих газар, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Эх, нярай,</p>
----	--	---

22	<p>5.3.6. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлөө шан харамж, бэлэг, албан бус төлбөр авахыг хориглосон зохицуулалтыг сурталчилсан агуулгатай контент бүтээж, түгээх;</p>	<p>Эрүүл мэндийн яам болон харьяа байгууллагуудын хэмжээнд 2023 онд "Таны баярлалаа гэдэг үг бидэнд хангалттай" уриан дор авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилан ажилласан.</p> <p>1. Энэ хүрээнд 2023 оны 09 дүгээр сард Эрүүл мэндийн яамнаас "Таны баярлалаа гэдэг үг бидэнд хангалттай" уриан дор 2 минутын контент бүтээж, ЭМЯ болон харьяа байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар дамжуулан түгээсэн. Холбоос: https://m.facebook.com/story.php?story_fbid=pfbid02FUxrqKzcATxwZy6nLmDDrGhfsdoKv8U2gQN6bHLdqYZPx1jUZx9wo2EttWK9NC4I&id=100069001246479&mbextid=Nif5oz</p> <p>2. Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-оос 2023 оны 11 дүгээр сард "Таны баярлалаа гэдэг үг бидэнд хангалттай" уриан дор үргэлжлүүлэн 01:30 секундын контент бүтээж түгээсэн. Холбоос: https://wetransfer.com/downloads/9ea807aca9a1a7793321a9db71daa47820231120041454/54d5de</p> <p>3. Улсын хоёрдугаар төв эмнэлгээс мөн дээрх уриан дор үргэлжлүүлэн 02:27 секундын контент бүтээж</p>
----	---	---

23	<p>5.3.7. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, эмнэлгийн ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг шуурхай, үнэн зөв шийдвэрлэх, иргэнд заавал хариу мэдэгдэх, зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p>		<p>ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд 94 өргөдөл, гомдол ирснээс 38 нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гомдол байна. Үүнээс үйлчлүүлэгчээс-эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой гомдол 10, эмнэлгийн мэргэжилтэн хоорондын ёс зүйтэй холбоотой 12, эмнэлгийн мэргэжилтэн-удирдах ажилтны ёс зүйтэй холбоотой 11 гомдол байна. 24 гомдлыг чиг үүргийн дагуу эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх ёс зүйн салбар хороонд хүргүүлж шийдвэрлэсэн. Ёс зүйн алдаа зөрчил гаргасан 5 хүнд Хөдөлмөрийн хуулийн дагуу сахилгын арга хэмжээ авсан. Эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх 33 ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн, тогтоол гаргасан. Эмнэлгийн мэргэжилтэн нарт ёс зүйн алдаа, зөрчлөөс сэргийлэх 1 багц цагийн сургалтын хөтөлбөр боловсруулж ЭМХТ-ийн hr.hdc.gov.mn цахимд байршуулсан. “Эрх зүйн боловсрол ба Эрүүл мэнд” нийгэмлэг, АШУҮИС-ийн Харилцааны ур чадварын тэнхим, Эм зүйн сургууль, УБ Төмөр замын НЭ, “Шинэ нийгмийн эрүүл мэнд” ТББ-д Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрх зүйн багц</p>

Хэрэгжилтийн хувь

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%

100%